Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 76 буюу 28.0 хувь нь гэр орон сууцанд, 40 буюу 14.8 хувь нь гудамж талбайд, 6 буюу 2.2 хувь нь олон нийтийн газарт, 10 буюу 3.7 хувь нь аж ахуйн нэгжид, 24 буюу 8.9 хувь нь авто замд, 115 буюу 42.4 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 86 буюу 31.7 хувь нь согтуугаар, 1 буюу 0.4 хувь нь хүүхэд оролцож, 20 буюу 7.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 17 буюу 6.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 25 буюу 9.2 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн
1	Алдархаан сум	6		2		
2	Асгат сум	1		1	1	
3	Баянтэс сум	1				
4	Баянхайрхан сум	1			1	1
5	Дөрвөлжин сум	1		1		
6	Завханмандал сум	3				1
7	Идэр сум	2				1
8	Их-Уул сум	2			1	1
9	Нөмрөг сум					
10	Отгон сум	2			1	3
11	Сантмаргац сум	6		1	1	2
12	Сонгино сум	1				2



13	Тосонцэнгэл сум	11	3	1	4
14	Түдэвтэй сум	2		1	
15	Тэлмэн сум	1			
16	Тэс сум				
17	Улиастай сум	34	1	12	3
18	Ургамал сум	2			
19	Цагаанхайрхан сум	2			
20	Цагаанчулуут сум				3
21	Цэцэн уул сум				
22	Шилүүстэй сум	6			3
23	Эрдэнэхайрхан сум	2			1
24	Яруу сум			1	
Нийт		86	1	20	17

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Завхан аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 147 буюу 54.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 62.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.0 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 2.8 нэгжээр өндөр байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 205 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7 хэрэг буюу 3.3 хувиар, үүнээс 127 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 17 буюу 11.8 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 222 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.6 хувиар өссөн. Холбогдогчдын 15 буюу 6.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 50.0 хувиар, 207 буюу 93.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 13.7 хувиар тус тус өссөн, 1 буюу 0.1 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 90.9 хувиар буурсан байна.


3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 293 иргэн хохирч, үүнээс 23 хүн нас барж, 93 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 46 буюу 18.6, нас барсан хүн 10 буюу 76.9, гэмтсэн хүн 13 буюу 16.2 хувиар тус тус өссөн байна.



4.2 Учирсан хохирол.




Иргэнд учирсан 1214.5 сая төгрөгийн хохирлын 41.1 хувийг нөхөн төлүүлж, 498.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 536.9 сая буюу 79.2, нөхөн төлүүлсэн хохирол 185.3 сая буюу 59.1, битүүмжилсэн хөрөнгө 173.5 сая буюу 53.4 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил

Завхан аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 16379 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1256 буюу 7.1 хувиар, 16333 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1271 буюу 7.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 15541 буюу 94.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 233 буюу 1.4 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 55 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 550 буюу 3.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 15644 иргэн, 9 хуулийн этгээдийг 624990.6 мянган төгрөгөөр торгох, 314 хүнийг баривчилах, 366 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 7.5 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 33 буюу 8.3 хувиар тус тус буурсан бол баривчилсан шийтгэл 26 буюу 9.0 хувиар өссөн байна.

2020 онд Завхан аймагт нийт 399 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 60 буюу 13.1 хувиар буурсан байна.

---oooOooo---



4.12 ОРХОН АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Орхон аймаг дахь цагдаагийн газар 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 6242 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1328 буюу 21.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 4914 буюу 78.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 62 буюу 1.0 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 244 буюу 4.7 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 182 буюу 15.9 хувиар өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 605 буюу 45.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 646 буюу 48.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 15 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 3943 буюу 80.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 902 буюу 18.4 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 33 буюу 0.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 533 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 214 буюу 28.6 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.3 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 622, сард 52, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:




1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.



1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 412 буюу 77.3 хувь нь хөнгөн, 121 буюу 22.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 23.6 хувиар, хүнд гэмт хэрэг 41.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2020 он.²⁷




²⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2019 он	2020 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	21	6	-71.4	1.1
	Үүнээс: Хүнийг алах	3	3		0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	195	214	9.7	40.2
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	8	3	-62.5	0.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	16	-5.9	3.0
	Үүнээс: Хүчиндэх	17	15	-11.8	2.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1		0.2
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		1		0.2
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1			
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	405	253	-37.5	47.4
7	Үүнээс Хулгайлах	226	127	-43.8	23.8
	Дээрэмдэх	8	8		1.5
	Залилах	114	84	-26.3	15.8
	Мал хулгайлах	8	7	-12.5	1.3
8	Эдийн засгийн гэмт хэрэг	4	6	50.0	1.1
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	32	6	-81.3	1.1
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	12	2	-83.3	0.4
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	19			
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	10	3	-70.0	0.6
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	3	5	66.7	0.9
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	27	20	-25.9	3.8
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	27	19	-29.6	3.6


1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 63 буюу 11.8 хувь нь даваа гарагт, 66 буюу 12.4 хувь нь мягмар гарагт, 82 буюу 15.4 хувь нь лхагва гарагт, 78 буюу 14.6 хувь нь пүрэв гарагт, 93 буюу 17.4 хувь нь баасан гарагт, 72 буюу 13.5 хувь нь бямба гарагт, 79 буюу 14.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 124 буюу 23.3 хувь нь 06:00-14:00 цагт, 155 буюу 29.1 хувь нь 14:00-19:00 цагт, 88 буюу 16.5 хувь нь 19:00-22:00 цагт, 166 буюу 31.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 260 буюу 48.8 хувь нь гэр орон сууцанд, 100 буюу 18.8 хувь нь гудамж талбайд, 36 буюу 6.8 хувь нь олон нийтийн газарт, 39 буюу 7.3 хувь нь аж ахуйн нэгжид, 20 буюу 3.8 хувь нь авто замд, 78 буюу 14.5 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 202 буюу 37.9 хувь нь согтуугаар, 16 буюу 3.0 хувь нь хүүхэд оролцож, 87 буюу 16.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 18 буюу 3.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 33 буюу 6.2 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Баян-Өндөр сум	195	16	86	18	31	1
2	Жаргалант сум	7		1		2	
Нийт		202	16	87	18	33	1

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Орхон аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 188 буюу 35.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 53.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.7 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 5.6 нэгжээр бага байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 336 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 368 хэрэг буюу 52.3 хувиар, үүнээс 180 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 244 буюу 57.5 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 421 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.6 хувиар буурсан. Холбогдогчдын 87 буюу 20.7 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд, 334 буюу 79.3 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 21.2 хувиар, 20 буюу 4.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 57.4 хувиар тус тус буурсан байна.


3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 544 иргэн хохирч, үүнээс 9 хүн нас барж, 249 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 142 буюу 20.7, нас барсан хүн 18 буюу 66.7 хувиар тус тус буурсан, гэмтсэн хүн 17 буюу 7.3 хувиар өссөн байна.




4.2 Учирсан хохирол.



Иргэнд учирсан 1859.7 сая төгрөгийн хохирлын 48.8 хувийг нөхөн төлүүлж, 8.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 751.2 сая буюу 28.8, нөхөн төлүүлсэн хохирол 46.8 сая буюу 4.9, битүүмжилсэн хөрөнгө 46.8 сая буюу 84.2 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил

Орхон аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 29213 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2447 буюу 7.7 хувиар, 29147 зөрчлийг шийдвэрлэсэн нь 2444 буюу 7.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 26633 буюу 91.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 76 буюу 0.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 256 буюу 0.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2248 буюу 7.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 27145 иргэн, 12 хуулийн этгээдийг 1483571.2 мянган төгрөгөөр торгох, 875 хүнийг баривчилах, 1115 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 6.7 хувиар, баривчилсан шийтгэл 47 буюу 5.1 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 431 буюу 27.9 хувиар тус тус буурсан байна.

2020 онд Орхон аймагт нийт 2559 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 638 буюу 20.0 хувиар буурсан байна.

---oooOooo---



4.13 ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 5452 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 693 буюу 12.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 4759 буюу 87.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 731 буюу 15.5, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 924 буюу 24.1 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 193 буюу 21.8 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 521 буюу 75.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 143 буюу 20.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 8 буюу 1.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 4141 буюу 87.0 хувийг зөрчлийн хэрэг нээж, 562 буюу 11.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 37 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 407 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 206 буюу 33.6 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 526, сард 44, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.


Д/д	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Арвайхээр	298	136	-162	-54.4
2	Баруунбаян-Улаан	12	7	-5	-41.7
3	Батөлзий	38	58	20	52.6
4	Баянгол	2	3	1	50.0
5	Баянөндөр	8	7	-1	-12.5
6	Богд	17	22	5	29.4
7	Бүрд	9	12	3	33.3
8	Гучин ус	12	9	-3	-25.0
9	Есөнзүйл	6	4	-2	-33.3
10	Зүүнбаянулаан	16	11	-5	-31.3
11	Нарийн тээл	16	6	-10	-62.5
12	Өлзийт	4	1	-3	-75.0
13	Сант	7	10	3	42.9
14	Тарагт	18	12	-6	-33.3
15	Төгрөг	7	4	-3	-42.9
16	Уянга	24	21	-3	-12.5
17	Хайрхан дулаан	18	22	4	22.2
18	Хархорин	73	42	-31	-42.5
19	Хужирт	28	20	-8	-28.6



1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 319 буюу 78.4 хувь нь хөнгөн, 88 буюу 21.6 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 30.2 хувиар, хүнд гэмт хэрэг 43.6 хувиар тус тус буурсан байна.

1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2020 он.²⁸




1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2019 он	2020 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	11	6	-45.5	1.5
	Үүнээс: Хүнийг алах	3	4	33.3	1.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	180	136	-24.4	33.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	6	4	-33.3	1.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	27	8	-70.4	2.0
	Үүнээс: Хүчиндэх	6	7	16.7	1.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	324	180	-44.4	44.2
6	Хулгайлах	199	88	-55.8	48.9
	Дээрэмдэх	28	26	-7.1	6.4
	Залилах	11			
	Мал хулгайлах	57	50	-12.3	12.3
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2			
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	2	-50.0	0.5
9	Авлигын эсрэг гэмт хэрэг	6	1	-83.3	0.2
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	7	75.0	1.7
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг	26	45	73.1	11.1
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	27	20	-25.9	4.9
12	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	26	20	-23.1	4.9

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 58 буюу 14.3 хувь нь даваа гарагт, 62 буюу 15.2 хувь нь мягмар гарагт, 71 буюу 17.4 хувь нь лхагва гарагт, 61 буюу 15.0 хувь нь пүрэв гарагт, 52 буюу 12.8 хувь нь баасан гарагт, 60 буюу 14.7 хувь нь бямба гарагт, 43 буюу 10.6 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 71 буюу 17.4 хувь нь 06:00-14:00 цагт, 105 буюу 25.8 хувь нь 14:00-19:00 цагт, 89 буюу 21.9 хувь нь 19:00-22:00 цагт, 142 буюу 34.9 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.




²⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.



1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 148 буюу 36.4 хувь нь гэр орон сууцанд, 46 буюу 11.3 хувь нь гудамж талбайд, 17 буюу 4.2 хувь нь олон нийтийн газарт, 9 буюу 2.2 хувь нь төрийн байгууллагад, 14 буюу 3.4 хувь нь аж ахуйн нэгжид, 20 буюу 4.9 хувь нь авто замд, 153 буюу 37.6 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 132 буюу 32.4 хувь нь согтуугаар, 38 буюу 9.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 50 буюу 12.3 хувь нь бүлэглэн, 18 буюу 4.4 хувь нь хүүхэд оролцож, 21 буюу 5.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Арвайхээр сум	59	5	21	14	11	
2	Баруунбаян-Улаан	3	1		1	2	
3	Батэлзий сум	12		4		11	1
4	Баянгол сум	1					
5	Баянөндөр сум	1					
6	Богд сум	6	6	1			
7	Бүрд сум	3	1			1	
8	Гучин ус сум	1	1	1		2	
9	Есөнзүйл сум	1					
10	Зүүнбаянулаан сум	5				3	
11	Нарийн тээл сум					4	
12	Өлзийт сум						
13	Сант сум	5	1	1		1	
14	Тарагт сум	2		3			
15	Төгрөг сум	1				1	
16	Уянга сум	9	2	3		3	
17	Хайрхан дулаан сум	6		1	2	5	
18	Хархорин сум	13		3	3	2	
19	Хужирт сум	4	1		1	4	
	Нийт	132	18	38	21	50	1

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Өвөрхангай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 183 буюу 45.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 52.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 6.6 нэгжээр бага байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 266 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 300 хэрэг буюу 53.0 хувиар, үүнээс 140 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 140 буюу 50.0 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 338 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.7 хувиар буурсан. Холбогдогчдын 34 буюу 10.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар өсч, 304 буюу 89.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 22.3 хувиар буурч, 20 буюу 5.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 411 иргэн хохирч, үүнээс 16 хүн нас барж, 153 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 207 буюу 33.5, нас барсан хүн 5 буюу 23.8, гэмтсэн хүн 55 буюу 26.4 хувиар тус тус буурсан байна.



4.2 Учирсан хохирол.




Иргэнд учирсан 772.9 сая төгрөгийн хохирлын 40.5 хувийг нөхөн төлүүлж, 69.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 287.3 сая буюу 27.1, битүүмжилсэн хөрөнгө 65.5 сая буюу 48.7 хувиар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 61.9 сая буюу 24.7 хувиар өссөн байна.

Тав. Зөрчил

Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 59829 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 16331 буюу 37.5 хувиар, 59566 зөрчлийг шийдвэрлэсэн нь 16302 буюу 37.7 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 53332 буюу 89.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 2044 буюу 3.4 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 155 буюу 0.3 хувийг





ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2020 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 9 буюу 0.0 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 4289 буюу 7.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 57040 иргэнийг 1860937.9 мянган төгрөгөөр торгох, 1418 хүнийг баривчилах, 1108 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 39.4 хувиар, баривчилсан шийтгэл 132 буюу 10.3 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 34 буюу 3.2 хувиар тус тус өссөн.

2020 онд Өвөрхангай аймагт нийт 462 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 695 буюу 60.1 хувиар буурсан байна.

---oooOooo---

4.14 ӨМНӨГОВЬ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 3300 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 992 буюу 30.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2308 буюу 69.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 36 буюу 1.1, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 43 буюу 4.5 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 7 буюу 0.3 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 585 буюу 59.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 377 буюу 38.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 3 буюу 0.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 1593 буюу 69.0 хувийг зөрчлийн хэрэг нээж, 489 буюу 21.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 79 буюу 3.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 458 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 57 буюу 11.1 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.4 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 434, сард 36, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.






ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2020 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Д/д	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Баяндалай	8	9	1	12.5	9	Номгон	8	10	2	25.0
2	Баяновоо	11	7	-4	-36.4	10	Сэврэй	6	6	0	0.0
3	Булган	8	6	-2	-25.0	11	Ханбогд	148	89	-59	-39.9
4	Гурвантэс	39	23	-16	-41.0	12	Ханхонгор	17	32	15	88.2
5	Даланзадгад	136	142	6	4.4	13	Хүрмэн	6	1	-5	-83.3
6	Мандал-Овоо	3	7	4	2.3 дах	14	Цогт овоо	11	14	3	27.3
7	Манлай	18	12	-6	-33.3	15	Цогтцэций	92	98	6	6.5
8	Ноён	4	2	-2	-50.0						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 368 буюу 80.3 хувь нь хөнгөн, 90 буюу 19.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 12.6 хувиар, хүнд гэмт хэрэг 4.3 хувиар тус тус буурсан байна.

1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2020 он.²⁹




1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2019 он	2020 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	14	13	-7.1	2.8
	Үүнээс: Хүнийг алах	5	9	80.0	2.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	177	181	2.3	39.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		3		0.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	21	13	-38.1	2.8
	Үүнээс: Хүчиндэх	12	7	-41.7	1.5
4	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	169	178	5.3	38.9
5	Үүнээс Хулгайлах	91	108	18.7	60.7
	Дээрэмдэх	2	3	50.0	0.7
	Залилах	29	26	-10.3	5.7
	Мал хулгайлах	13	22	69.2	4.8
6	Эдийн засгийн гэмт хэрэг	29	6	-79.3	1.3
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	1			
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	9	9	0.0	2.0
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2			
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	10			
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	7	5	-28.6	1.1
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	12	11	-8.3	2.4
13	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1			
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	62	40	-35.5	8.7
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	61	40	-34.4	8.7
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.2

²⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.


1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 67 буюу 14.6 хувь нь даваа гарагт, 86 буюу 18.8 хувь нь мягмар гарагт, 55 буюу 12.0 хувь нь лхагва гарагт, 57 буюу 12.4 хувь нь пүрэв гарагт, 70 буюу 15.3 хувь нь баасан гарагт, 64 буюу 14.0 хувь нь бямба гарагт, 59 буюу 12.9 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол 97 буюу 21.2 хувь нь 06:00-14:00 цагт, 126 буюу 27.5 хувь нь 14:00-19:00 цагт, 66 буюу 14.4 хувь нь 19:00-22:00 цагт, 169 буюу 36.9 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 182 буюу 39.7 хувь нь гэр орон сууцанд, 41 буюу 9.0 хувь нь гудамж талбайд, 15 буюу 3.3 хувь нь олон нийтийн газарт, 6 буюу 1.3 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 37 буюу 8.1 хувь нь аж ахуйн нэгжид, 40 буюу 8.7 хувь нь авто замд, 135 буюу 29.5 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 154 буюу 33.6 хувь нь согтуугаар, 52 буюу 11.1 хувь нь эмэгтэй хүн оролцож, 46 буюу 10.0 хувь нь бүлэглэн, 5 буюу 1.1 хувь нь хүүхэд оролцож, 15 буюу 3.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Баяндалай сум	1	1	2	1	2	
2	Баяновоо сум	2		1			
3	Булган сум	2				2	
4	Гурвантэс сум	11		2		2	
5	Даланзадгад сум	67	2	22	8	7	
6	Мандал овоо сум	2				2	1
7	Манлай сум	2		1			
8	Ноён сум	1					
9	Номгон сум	1				4	
10	Сэврэй сум	1				1	
11	Ханбогд сум	26		7	3	7	
12	Ханхонгор сум	7		5		8	1
13	Хүрмэн сум			1			
14	Цогт овоо сум	3	2	2	1	5	
15	Цогтцэций сум	28		9	2	6	
Нийт		154	5	52	15	46	2




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Өмнөговь аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 184 буюу 40.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 57.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 2.2 нэгжээр бага байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.



Хэрэг бүртгэлтийн 349 хэрэг нээн шалгасан нь өмнө оны мөн үетэй харьцуулбал 90 хэрэг буюу 20.5 хувиар, үүнээс 199 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 52 буюу 20.7 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 385 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 хувиар өссөн. Холбогдогчдын 52 буюу 13.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өсч, 333 буюу 86.5 хувь нь эрэгтэй хүн байгаа 0.3 хувиар, 6 буюу 1.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 57.1 хувиар тус тус буурсан байна.


3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 461 иргэн хохирч, үүнээс 30 хүн нас барж, 225 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 79 буюу 14.6, нас барсан хүн 4 буюу 11.8, гэмтсэн хүн 28 буюу 11.1 хувиар тус тус буурсан байна.



4.2 Учирсан хохирол.




Иргэнд учирсан 2471.8 сая төгрөгийн хохирлын 37.0 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 897.4 сая буюу 57.0 хувиар өсч, нөхөн төлүүлсэн хохирол 285.3 сая буюу 23.8 хувиар буурсан байна.

/сая төг-өөр/

Тав. Зөрчил

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 17535 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1776 буюу 9.2 хувиар, 17491 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1715 буюу 8.9 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 16113 буюу 91.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 116 буюу 0.7 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 38 буюу 0.2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 6 буюу 0.0 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1262 буюу 7.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 16586 иргэн, 15 хуулийн этгээдийг 927688.3 мянган төгрөгөөр торгох, 253 хүнийг баривчилах, 637 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 9.1 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 111 буюу 14.8 хувиар тус тус буурч, баривчилсан шийтгэл 50 буюу 24.6 хувиар өссөн байна.

2020 онд Өмнөговь аймагт нийт 1098 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 322 буюу 22.7 хувиар буурсан байна.

---oooOooo---



4.15 СҮХБААТАР АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 2525 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 794 буюу 31.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1731 буюу 68.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 145 буюу 6.1 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 356 буюу 25.9 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 211 буюу 21.0 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 390 буюу 49.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 347 буюу 43.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 19 буюу 2.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 1445 буюу 83.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 262 буюу 15.1 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 18 буюу 1.04 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 408 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 117 буюу 22.3 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 329, сард 27, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:




1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.



1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 302 буюу 74.0 хувь нь хөнгөн, 106 буюу 26.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 27.6 хувиар, хүнд гэмт хэрэг 1.9 хувиар тус тус буурсан байна.

1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2020 он.³⁰




1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2019 он	2020 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	8	11	37.5	2.7
	Үүнээс: Хүнийг алах	1	7	7.0 дах	1.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	115	104	-9.6	25.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1	4	4.0 дах	1.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	15	15	0.0	3.7
	Үүнээс: Хүчиндэх	14	10	-28.6	2.5
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2	4	2.0 дах	1.0
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1			
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1			
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	314	233	-25.8	57.1
	Хулгайлах	104	91	-12.5	22.3
	Дээрэмдэх	4	1	-75.0	0.2
	Залилах	33	29	-12.1	7.1
	Мал хулгайлах	149	86	-42.3	21.1
8	Эдийн засгийн гэмт хэрэг	14	1	-92.9	0.2
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2			
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	11			
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	3	-25.0	0.7
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	1	14	14.0 дах	3.4
13	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.5
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	34	21	-38.2	5.1
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	33	21	-36.4	5.1

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 60 буюу 14.7 хувь нь даваа гарагт, 50 буюу 12.3 хувь нь мягмар гарагт, 52 буюу 12.7 хувь нь лхагва гарагт, 62 буюу 15.2 хувь нь пүрэв гарагт, 68 буюу 16.7 хувь нь баасан гарагт, 55 буюу 13.4 хувь нь бямба гарагт, 61 буюу 15.0 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 61 буюу 15.0 хувь нь 06:00-14:00 цагт, 113 буюу 27.7 хувь нь 14:00-19:00 цагт, 70 буюу 17.2 хувь нь 19:00-22:00 цагт, 164 буюу 40.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

³⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.



1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 122 буюу 29.9 хувь нь гэр орон сууцанд, 23 буюу 5.6 хувь нь гудамж талбайд, 23 буюу 5.6 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 5 буюу 1.2 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 9 буюу 2.2 хувь нь аж ахуйн нэгжид, 21 буюу 5.1 хувь нь авто замд, 202 буюу 49.7 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 121 буюу 29.7 хувь нь согтуугаар, 22 буюу 5.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 38 буюу 9.3 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.2 хувь нь хүүхэд оролцож, 25 буюу 6.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.


Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Асгат сум					1	
2	Баруун урт сум	58	1	16	14	4	
3	Баяндэлгэр сум	5		1	2		
4	Дарьганга сум	1		1	1	8	
5	Мөнххаан сум	10			3	5	1
6	Наран сум	2					
7	Онгон сум	4		2			
8	Сүхбаатар сум	12			1		
9	Түвшинширээ сум	8			2		
10	Түмэнцогт сум	4				4	
11	Уулбаян сум	3			1	1	
12	Халзан сум	2				1	
13	Эрдэнэцагаан сум	12		2	1	14	
Нийт		121	1	22	25	38	1

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Сүхбаатар аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 263 буюу 64.5 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 51.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 7.8 нэгжээр бага байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 257 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 179 хэрэг буюу 41.1 хувиар, үүнээс 132 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 78 буюу 37.1 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 331 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.3 хувиар буурсан. Холбогдогчдын 20 буюу 6.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар өссөн, 311 буюу 94.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 5.2 хувиар, 1 буюу 0.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 93.8 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 426 иргэн хохирч, үүнээс 32 хүн нас барж, 111 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 107 буюу 20.1 хувиар, гэмтсэн хүн 28 буюу 20.1 хувиар тус тус буурч, нас барсан хүн 15 буюу 88.2 хувиар өссөн байна.



4.2 Учирсан хохирол.




Иргэнд учирсан 1445.6 сая төгрөгийн хохирлын 71.7 хувийг нөхөн төлүүлж, 35.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 46.8 сая буюу 3.1 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 34.7 буюу 49.1 хувиар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 409.8 сая буюу 65.4 хувиар өссөн байна.



Тав. Зөрчил

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 14214 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4776 буюу 50.6 хувиар, 14091 зөрчлийг шийдвэрлэсэн нь 4702 буюу 50.1 хувиар тус тус өссөн.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 13125 буюу 92.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 256 буюу 1.8 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 153 буюу 1.1 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 4 буюу 0.03 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 676 буюу 4.8 хувийг бусад төрлийн зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 13508 иргэн, 8 хуулийн этгээдийг 602070.0 мянган төгрөгөөр торгох, 214 хүнийг баривчилах, 361 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 52.4 хувиар, баривчилсан шийтгэл 54 буюу 33.8 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

2020 онд Сүхбаатар аймагт нийт 499 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 41 буюу 7.6 хувиар буурсан байна.

---oooOooo---

4.16 СЭЛЭНГЭ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 3196 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1109 буюу 34.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2087 буюу 65.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 258 буюу 7.5 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 126 буюу 10.2 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 132 буюу 5.9 хувиар тус тус буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 670 буюу 60.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 371 буюу 33.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 25 буюу 2.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 866 буюу 41.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 1075 буюу 51.5 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 129 буюу 6.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 549 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 218 буюу 28.4 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.5 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 704, сард 59, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.






ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2020 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Д/д	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алтанбулаг	61	29	-32	-52.5	10	Сайхан	43	36	-7	-16.3
2	Баруунбүрэн	19	17	-2	-10.5	11	Сант	10	8	-2	-20.0
3	Баянгол	54	45	-9	-16.7	12	Сүхбаатар	137	98	-39	-28.5
4	Ерөө	64	55	-9	-14.1	13	Түшиг	10	4	-6	-60.0
5	Жавхлант	14	10	-4	-28.6	14	Хушаат	13	10	-3	-23.1
6	Зүүнбүрэн	14	5	-9	-64.3	15	Хүдэр	22	13	-9	-40.9
7	Мандал	218	149	-69	-31.7	16	Цагааннуур	29	17	-12	-41.4
8	Орхон	15	14	-1	-6.7	17	Шаамар	22	20	-2	-9.1
9	Орхонтуул	22	19	-3	-13.6						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 453 буюу 82.5 хувь нь хөнгөн, 96 буюу 17.5 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 23.2 хувиар, хүнд гэмт хэрэг 45.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2020 он.³¹



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2019 он	2020 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	21	21	0.0	3.8
	Үүнээс: Хүнийг алах	8	10	25.0	1.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	184	176	-4.3	32.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	7	1	-85.7	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	32	18	-43.8	3.3
	Үүнээс: Хүчиндэх	24	13	-45.8	2.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2	10	5.0 дах	1.8
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	330	204	-38.2	37.0
7	Үүнээс: Хулгайлах	154	75	-51.3	13.7
	Дээрэмдэх	13	7	-46.2	1.3
	Залилах	48	40	-16.7	7.3
	Мал хулгайлах	66	49	-25.8	8.9
8	Эдийн засгийн гэмт хэрэг	9	2	-77.8	0.4
9	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	9	9	0.0	1.6
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.4
12	Авлигын эсрэг гэмт хэрэг	17	1	-94.1	0.2
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	9	7	-22.2	1.3
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг	111	67	-39.6	12.2
15	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.2

³¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

16	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	39	29	-25.6	5.3
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	39	29	-25.6	5.3

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл: 78 буюу 14.2 хувь нь даваа гарагт, 96 буюу 17.5 хувь нь мягмар гарагт, 92 буюу 16.8 хувь нь лхагва гарагт, 78 буюу 14.2 хувь нь пүрэв гарагт, 69 буюу 12.6 хувь нь баасан гарагт, 59 буюу 10.7 хувь нь бямба гарагт, 77 буюу 14.0 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 142 буюу 25.9 хувь нь 06:00-14:00 цагт, 154 буюу 28.1 хувь нь 14:00-19:00 цагт, 75 буюу 13.7 хувь нь 19:00-22:00 цагт, 178 буюу 32.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 174 буюу 31.7 хувь нь гэр орон сууцанд, 59 буюу 10.7 хувь нь гудамж талбайд, 27 буюу 4.9 хувь нь олон нийтийн газарт, 21 буюу 3.8 хувь нь аж ахуйн нэгжид, 30 буюу 5.5 хувь нь авто замд, 238 буюу 43.4 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 170 буюу 31.0 хувь нь согтуугаар, 9 буюу 1.6 хувь нь хүүхэд оролцож, 72 буюу 13.1 хувь нь эмэгтэй хүн оролцож, 39 буюу 7.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн үлмаас, 57 буюу 10.4 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн үлмаас	Бүлэглэн үйлдсэн
1	Алтанбулаг	11	2	8	2	4
2	Баруун бүрэн	5		3		3
3	Баянгол	6	1	2	1	10
4	Ерөө	13		4	3	8
5	Жавхлант	1		2		2
6	Зүүн бүрэн	2				1
7	Мандал	53	3	27	12	6
8	Орхон	1				3
9	Орхонтуул	6		1		4
10	Сайхан	12	1	6	5	2
11	Сант	1				1
12	Сүхбаатар	42	2	17	12	6
13	Түшиг				1	
14	Хушаат	4			1	1
15	Хүдэр	2				2
16	Цагаан нуур	4		1	1	1
17	Шаамар	7		1	1	3
	Нийт	170	9	72	39	57




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Сэлэнгэ аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 192 буюу 35.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 54.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 5.2 нэгжээр бага байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 420 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 174 хэрэг буюу 29.3 хувиар, үүнээс 227 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 97 буюу 29.9 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 426 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.7 хувиар буурсан. Холбогдогчдын 53 буюу 12.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 25.4 хувиар, 373 буюу 87.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 23.4 хувиар, 12 буюу 2.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 77.8 хувиар тус тус буурсан байна.


3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 537 иргэн хохирч, үүнээс 34 хүн нас барж, 207 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 208 буюу 27.9, нас барсан хүн 3 буюу 8.1, гэмтсэн хүн 40 буюу 16.2 хувиар тус тус буурсан байна.



4.2 Учирсан хохирол.




Иргэнд учирсан 1294.2 сая төгрөгийн хохирлын 53.6 хувийг нөхөн төлүүлж, 124.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 1406.5 сая буюу 52.1, нөхөн төлүүлсэн хохирол 428.9 сая буюу 38.2, битүүмжилсэн хөрөнгө 119.1 сая буюу 48.9 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил

Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 19708 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6791 буюу 25.6 хувиар буурч, 19615 зөрчлийг шийдвэрлэсэн нь 6753 буюу 25.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 17924 буюу 90.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 758 буюу 3.8 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 131 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 895 буюу 4.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 18659 иргэн, 10 хуулийн этгээдийг 877728.4 мянган төгрөгөөр торгох, 336 хүнийг баривчилах, 610 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 25.8 хувиар, баривчилсан шийтгэл 62 буюу 15.6 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 217 буюу 26.2 хувиар тус тус буурсан байна.

2020 онд Сэлэнгэ аймагт нийт 1335 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 535 буюу 28.6 хувиар буурсан байна.

---oooOooo---



4.17 ТӨВ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Төв аймаг дахь цагдаагийн газар 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 4220 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1616 буюу 38.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2604 буюу 61.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 72 буюу 1.7, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 143 буюу 5.8 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 71 буюу 4.2 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 469 буюу 29.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1104 буюу 68.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 10 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 2204 буюу 84.6 хувийг зөрчлийн хэрэг нээж, 308 буюу 11.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 5 буюу 0.2 хувийг ердийн зөрчлөөр, 84 буюу 3.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 737 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 128 буюу 14.8 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 8.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 818, сард 68, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.




Д/д	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алтанбулаг	27	28	1	3.7	15	Дэлгэрхаан	10	5	-5	-50.0
2	Архуст	9	7	-2	-22.2	16	Жаргалант	31	30	-1	-3.2
3	Аргалант	33	35	2	6.1	17	Заамар	45	43	-2	-4.4
4	Батсүмбэр	44	38	-6	-13.6	18	Зуунмод	155	131	-24	-15.5
5	Баян	32	13	-19	-59.4	19	Лүн	24	30	6	25.0
6	Баяндэлгэр	15	12	-3	-20.0	20	Мөнгөнморьт	10	14	4	40.0
7	Баянжаргалан	10	9	-1	-10.0	21	Өндөрширээт	23	23	0	0.0
8	Баянөнжүүл	32	20	-12	-37.5	22	Сүмбэр	9	6	-3	-33.3
9	Баянхангай	14	23	9	64.3	23	Сэргэлэн	89	67	-22	-24.7
10	Баянцагаан	28	17	-11	-39.3	24	Угтаалцайдам	11	11	0	0.0
11	Баянцогт	21	24	3	14.3	25	Цээл	9	15	6	66.6
12	Баянчандмань	44	18	-26	-59.1	26	Эрдэнэ	64	51	-13	-20.3
13	Борнуур	43	21	-22	-51.2	27	Эрдэнэсант	23	36	13	56.5
14	Бүрэн	10	10	0	0.0						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 610 буюу 82.8 хувь нь хөнгөн, 127 буюу 17.2 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 14.6 хувиар, хүнд гэмт хэрэг 15.9 хувиар тус тус буурсан байна.

1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2020 он.³²



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2019 он	2020 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	43	13	-69.8	1.8
	Үүнээс: Хүнийг алах	8	7	-12.5	0.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	210	273	30.0	37.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	3	-40.0	0.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8	7	-12.5	0.9
	Үүнээс: Хүчиндэх	7	6	-14.3	0.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	408	306	-25.0	41.8
5	Хулгайлах	158	138	-12.7	18.7
	Дээрэмдэх	1			
	Залилах	17	30	76.5	4.1
	Мал хулгайлах	199	100	-49.7	13.6
6	Эдийн засгийн гэмт хэрэг	7	1	-85.7	0.1
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	15	7	-53.3	0.9
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	4	-33.3	0.5
9	Авлигын эсрэг гэмт хэрэг	15			
